

УВС АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЧИМЭД ОВОГТОЙ ЭНХТӨР МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Уриа: Шударга ёсыг хамтдаа бүтээцгээ

1. Шинээр байгуулагдсан болон боловсон хүчний хувьд бүрэн бэхжээгүй компани, хоршоо, нөхөрлөлийг Увс аймагт орон нутгийн болон улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудад туслан гүйцэтгэгчээр ажиллуулан ажлын туршлагатай болгох, шударга өрсөлдөөн бий болгох бодлого баримтална.
2. Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалын хууль бус олборлолтыг зогсоож, хяналт шалгалтыг сайжруулан, төлбөр үнэлгээг шинэчлэх, мөрдүүлэх ажлыг санаачилна.
3. Төрийн болон төрийн үйлчилгээний албан хаагч бүхэнд иргэдийн эрх ашиг нэгдүгээрт байх ёстой. Төрийн албан дахь хүнд суртлыг бүрэн арилгана.
4. Увс аймагт гарч байгаа хүчирхийлэл, хүний эрхийн зөрчил, гомдлыг шуурхай шалгаж, шийдвэрлэдэг болно.
5. Суманд ажиллахаар очсон эмч, эмнэлгийн ажилтнуудыг тогтвортой ажиллуулах үүднээс бага хүүтэй зээлд хамруулж, орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх замаар боловсон хүчний бодлого алдагдуулахгүй байх хөтөлбөр боловсруулна.
6. Аливаа төсөл, тендерийн шалгаруулалт, концесс, бараа ажил үйлчилгээ худалдан авах шалгаруулалт, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд очих зээлд хяналт тавьж ажиллана.
7. ЖДҮ-ийг шинэчлэх замаар өрхийн бизнес эрхлэгчдийг дэмжинэ.
8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд ямар ч саадгүй оролцох боломж бүрдүүлнэ. Тэднийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлнэ.
9. Иргэн бүр ажилтай, орлоготой байх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
10. Орон нутгийн төсөвт төвлөрдөг орлого болон АМНАТ буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тодорхой хувийг иргэдийг ажлын байраар хангах, нийгмийн салбарт төсөл хөтөлбөрт санхүүжүүлэх бодлого баримтална.
11. Их, дээд сургууль төгссөн залуусыг төрийн албанд намын харьяалгүй ажиллуулах боломж бүрдүүлнэ. Ажилгүй залуусыг аж ахуйн нэгж байгуулж, нийгэмд залуусын оролцоог нэмэгдүүлэх замаар төсөл хөтөлбөрт хамруулж, дэмжлэг үзүүлэх бодлого баримтална.
12. Увс аймагт үйл ажиллагаа явуулж буй Хөдөлмөрийн дээд сургууль, “Улаангом коллеж”-д сурч байгаа болон төгсөгчдийг төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй хамтарч ажиллах боломж бүрдүүлнэ.

13. Аймаг, сум, багийг холбосон алсын зайн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээний сүлжээ бий болгоно.

14. Увс аймагт төрийн албанд ах, дүү, хамаатан садан, танилаа оруулж, ажил цалгардуулдаг байдлыг болиулж, хуульд заасан төрийн албаны мерит тогтолцоог барьж ажиллана.

15. Малчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд тогтмол хамруулах, явуулын эрүүл мэндийн үйлчилгээг тогтмол болгоно.

НЭР ДЭВШИГЧ:  Ч.ЭНХТӨР